



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 17,000,000.00 (арван долоон сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадорж, Арьсны өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Ц.Уранчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


А.АРИУНБОЛД

0000439

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн
AMZ дугаар тогтоолын хавсралт



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэр-лэсэн/Ашигглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Киа Рио, 97-12 УНН, суудлын, арал-KNADE221296474186, хөдөлгүүр-G4EE84189197	2008/2009	92,674	17,000,000	17,000,000	-	2,000,000.00
	Нийт дүн	-	-	17,000,000.00 (арван долоон сая)	17,000,000.00 (арван долоон сая)	-	2,000,000.00 (хоёр сая)